



Монгол Улсын Их
Хурлын Тамгын газар



Schweizerische Eidgenossenschaft
Confédération suisse
Confederazione Svizzera
Confederaziun svizra

Swiss Agency for Development
and Cooperation SDC




Empowered lives.
Resilient nations.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ ДЭГИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН БАЙДАЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

ЗӨВЛӨМЖ

Л.ӨЛЗИЙСАЙХАН



ӨМНӨХ ҮГ



Монгол Улсын Их Хурлын Тамгын газар, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөр, Швейцарын хөгжлийн агентлагын хамтран хэрэгжүүлж буй “Монгол Улсын төлөөллийн байгууллагыг бэхжүүлэх нь” төслийн хүрээнд гүйцэтгэсэн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль (2007)-ийн хэрэгжилтийн байдалд хийсэн дүн шинжилгээний тайланг Та бүхэнд толилуулж байна.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль бол Байнгын, дэд, түр хороо, нэгдсэн чуулганаар хэлэлцэх хууль, бусад шийдвэрийн төсөл боловсруулах, төслийн хэлэлцүүлгийг явуулах, эцэслэн батлах зэрэг Улсын Их Хурлын өдөр тутмын үйл ажиллагааны журмыг тогтоосон парламентын бие даасан, хараат бус байдлын баталгаа юм.

Парламент судлаач Л.Өлзийсайхан Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн хуульд дүн шинжилгээ хийхдээ парламентын хуралдааны дэгийн орчин үеийн онол, хандлагыг баримтлан дэгээр зохицуулах асуудал бүрийн хүрээнд парламентад өсөндөр түвшинд хөгжсөн гадаадын зарим улсын эрх зүйн зохицуулалтыг харьцуулан судалж, дэгийн зохицуулалтыг боловсронгуй болгох талаар тодорхой санал зөвлөмж дэвшүүлжээ.

Энэ дүн шинжилгээгээр Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн хэрэгжилтэд парламентын хуралдааны дэгийн онол, зарчмын үүднээс үнэлэлт, дүгнэлт өгөхийн зэрэгцээ “парламентын эрх зүй”-г бүрдүүлэгч гол хуулиуд болох Монгол Улсын Их Хурлын тухай, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль хоорондын давхцал болон хийдэл, тэдгээрийг хуулийн системчлэлийн үүднээс хэрхэн шийдвэрлэх талаар санал зөвлөмж боловсруулсан байна.

Мөн Үндсэн хуулийн цэцээс Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн холбогдох зүйл, заалт Үндсэн хууль зөрчсөн эсэх талаар гаргасан дүгнэлт, тогтоолыг судалж, дүн шинжилгээ хийсэн нь хууль тогтоогчид болон эрдэмтэн судлаачид, практик ажилтнуудын зүгээс парламентын эрх зүйн хөгжлийг “иж бүрэн”-ээр нь харах, парламентын эрх зүйн шинэчлэлийг шинжлэх ухааны үндэслэлтэй, бодитой судалгаа шинжилгээнд тулгуурлан хэрэгжүүлэх нөхцөл боломжийг бүрдүүлж байна.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН, ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА, ТӨСЛИЙН
УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Проф. Д.ЛҮНДЭЭЖАНЦАН
(Sc. D, Ph. D)



Нэг. Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулиар УИХ-ын бие даасан байдлыг бэхжүүлэх, хангахтай холбоотой зөвлөмж

1.1. Үндсэн хууль ба Улсын Их Хурлын бие даасан байдал:

- (1) Парламентын хуралдааны дэгийг “бүхнийг хуулиар зохицуулна” гэж байсан үеийн хууль зүйн техникээр бичигдэж байсан зарчим ард үлдэж байгааг ухаарч, Үндсэн хуулиа зөв уншиж, тайлбарлаж, дэлхий нийтийн жишгийн дагуу эрх зүйн хэлбэрийн хувьд “тогтоол”-оор батлах, улмаар парламентын өөртөө засаглах эрхийг хүлээн зөвшөөрөх, баталгаажуулах;
- (2) “Дэг тогтоогч нь парламент өөрөө мөн”¹ гэсэн зарчмыг Улсын Их Хурлын хууль тогтоомжид тусгах. Тодруулж хэлбэл, Улсын Их Хурал зохистой гэсэн дэгийг өөрөө сонгож хэрэглэх, бусад эрх мэдлийн институт (Засгийн газар, Ерөнхийлөгч)-ын оролцоогүйгээр дэгээ тогтоож, өөрчлөх, тайлбарлах эрхтэй. Улсын Их Хурал хэдийд ч дэгээ өөрчлөх, шинэчлэх болон тохиромжтой гэсэн дэгийг олонхийн саналаар сонгон хэрэглэх эрхийг баталгаажуулах;
- (3) Монгол Улсын шинэ Үндсэн хуулийг баталж, парламентат ёсыг төлөвшүүлэх эхэн үед буюу 1992 оны 9 дүгээр сард Шведийн Стокхольмд Парламентын хуралдааны дэгийн шинэтгэлийн асуудлаар Олон улсын парламентын холбооны дэргэдэх Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга нарын нийгэмлэгээс зохион байгуулсан хуралдаанаас гаргасан “парламентын хуралдааны дэгийг хуулиар бус тогтоолоор батлах нь тухайн парламентын бие даасан, хараат бус-автономи байдалтай зайлшгүй холбогдох учраас аливаа улс орны парламент эл асуудлыг анхааралдаа авах нь зайлшгүй юм” гэсэн зөвлөмжийг анхаарах;
- (4) 1997 онд Польшийн нийслэл Варшавт ардчилсан парламентын засагт шилжсэн хуучин социалист орнууд парламентын бие даасан байдал болон түүний хуралдааны дэгийн асуудлаар

¹ Л.Өлзийсайхан. Парламентын хуралдааны дэгийн онол, арга зүйн үндэс. УБ., 2010 он. 45-53 дахь тал.



хуралдаж гаргасан парламентын хуралдааны дэгийг хуульчлах нь түүний үйл ажиллагаа, бие даасан тусгаар-автономи байдлыг алдагдуулах учраас тогтоолоор батлах нь зүйтэй гэсэн нэгдсэн зөвлөмжийг анхаарах;

- (5) Дэлхийн улс орнуудын жишгээр УИХ хуралдааны дэгээ ямар эрх зүйн хэлбэрээр батлах зохицуулалтыг Үндсэн хуулиар нарийвчлан тодорхой болгож, Улсын Их Хурал хуралдааны дэгээ “хуулиар” бус тогтоолоор буюу “хууль тогтоомж”-оор батална гэсэн заалтыг Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 4 дэх хэсэгт өөрчлөлт оруулах замаар хуульчлах;
- (6) Үндсэн хуульд дээр дурдсан өөрчлөлтийг тусгах боломжгүй бол Үндсэн хуулийн тайлбарын аргаар сул талыг нөхөж тогтоолоор батлан дагаж мөрдөх. Учир нь хууль гэдэг бол тухайн цаг үеийн бүтээгдэхүүн байдаг (Үндсэн хууль батлагдаад 27 жил болж байна) бөгөөд эл сул талыг нөхөх зорилгоор тухайн заалтыг тайлбарлахдаа орчин үед эрх зүйн либерал тайлбарыг ашиглах хандлага түгээмэл байна. Уг хандлага нь тухайн Үндсэн хуулийн болон бусад хуулийн хэм хэмжээг хөгжлийн хүрсэн түвшинд нь үнэлэн тайлбарлах явдал юм.

1.2. Хуралдааны дэг ба хууль санаачлах эрх:

- (1) Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгд нэмэлт, өөрчлөлт оруулахаар Ерөнхийлөгчөөс 5 удаа болон Засгийн газраас 7 удаа хуулийн төсөл боловсруулсныг Улсын Их Хурал хуралдаанаараа баталж, улмаар дагаж мөрдөж байгаа нь өөрийнхөө дархлааг сулруулж байгаа явдал бөгөөд үүнд дүгнэлт өгч, холбогдох хууль тогтоомжийг өөрчлөх;
- (2) Улсын Их Хурлын гишүүнээс санаачилсан Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, санал авч байгаа практикийг хориглох.
- (3) Парламентын хуралдааны дэгийн онол, арга зүй, түүний хэм хэмжээг боловсруулах арга, зарчим, хууль зүйн техникийн талаар бусад улсын туршлагыг судлан авч хэрэгжүүлэх;



1.3. Хуралдааны дэгийг шинээр бүрдсэн Улсын Их Хурал бүр батлах эсэх:

- (1) Улсын Их Хурлын тухай хуульд шинээр бүрдсэн парламент өмнөх УИХ-ын хуралдааны дэгийг цааш үргэлжлүүлэн авч явах, эсхүл өөрсдийн дэгээ шинээр тогтоох эсэх асуудлыг хэлэлцэх заалтыг 2012 оны 12 дугаар сарын 21-ний өдөр нэмэлтээр оруулсан нь монголын парламент анх удаа бие даасан тусгаар-автономи байдлын зарчмыг баталгаажуулсан явдал юм. Гэвч энэ зарчмыг дэгд тусгахдаа хэрэгжүүлэх процессыг орхигдуулж, тунхаг байдлаар зохицуулсныг Монгол Улсын Их Хурлын 7 дахь удаагийн сонгуулиар байгуулагдсан парламент (2016-2020)-ын анхдугаар чуулган дээр уг заалтыг хэрхэн хэрэгжүүлэх талаар үүссэн маргаан нотолно. Иймд шинээр бүрдсэн УИХ хуралдааны дэгээ өөрөө батлах эсэх асуудлаар дээр дурдсан анхдугаар чуулган дээр үүссэн кейсийг бүхэлд нь нарийвчлан судалж, шинээр бүрдсэн парламент дэгээ батлахтай холбоотой заалтыг олон улсын жишиг, стандартын дагуу нарийвчлан зохицуулж нэг мөр болгох.

1.4. Хуралдааны дэг, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах журам:

- (1) Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд түүнд оруулах нэмэлт, өөрчлөлтийн журмыг зохицуулсан заалтыг шинээр хуульчлах;
- (2) Ерөнхийлөгч, Засгийн газар бус зөвхөн Улсын Их Хурлын гишүүд хуралдааны дэгд нэмэлт, өөрчлөлт оруулах эрхтэй болохыг Улсын Их Хурлын болон холбогдох хууль тогтоомжуудаар баталгаажуулах.

1.5. Хуралдааны дэгийг хэлэлцэх асуудлын дараалал үл харгалзан хэлэлцэх:

- (1) Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд дэгийн асуудлаар санаачилсан төслийг хэлэлцэх асуудлын



дараалал баримтлахгүй хэлэлцүүлэгт шууд оруулах тухай заалтыг хуульчлах;

1.6. Хуралдааны дэгийн асуудлыг эрхлэх Байнгын хороо:

- (1) Харьцуулсан судалгаагаар улс орнуудын парламентад нийтлэг ажиглагдаж байгаа зүйл бол Дэгийн хороо бөгөөд тус хороо нь байнгын ажиллагаатай байна. Иймд Дэгийн байнгын хороог дахин байгуулж, чиг үүргийг нарийвчлан зааж өгсөн зохицуулалтыг хуульчлах.

1.7. Хуралдааны дэгийг тайлбарлах:

- (1) УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн зарим зүйл, заалтыг зөв хэрэглэх талаар нэгдсэн болон Байнгын хорооны хуралдаан дээр маргаан гарсан тохиолдолд хуулийн заалттай холбоотой тайлбарыг хуралдаан даргалагч хийх, түүний хэлсэн тайлбартай холбоотой маргаан гарсан тохиолдлыг хэрхэн шийдвэрлэх журмыг тогтоох
- (2) Нэгдсэн болон Байнгын хорооны хуралдаан дээр хуралдааны дэгийн тухай хуулийн зарим зүйл, заалтыг хэрэглэх талаар гарсан маргаантай холбоотойгоор Тамгын газрын ажилтан шууд тайлбар хийж байгаа өнөөгийн практикийг хязгаарлах. Харин хуралдаан даргалагчид зөвлөх чиг үүргийг гүйцэтгүүлэх.

1.8. Хуралдааны дэгийг баримтлахгүй байх болон түдгэлзүүлэх тохиолдол:

- (1) Ер нь парламентын хурлын дэгийн үүсэл бол хүмүүсийн толгойг эргүүлэх гэж юм уу, эсхүл парламент дахь олонхи болон цөөнхийн хүсэл зоригт саад болох гэж бий болоогүйг түүхээс харж болно. Харин ч эсрэгээрээ ба дэг бол үйл ажиллагааны янз бүрийн дэг журмууд болон янз бүрийн ашиг сонирхолтой хүмүүсийг зохицуулахаар бодож олсон **логик аргачлал** юм. Иймд парламентын хуралдааны дэгийн заалтууд бол



парламентаар хэлэлцүүлж байгаа болон шинээр хэлэлцүүлэх гэж буй аливаа асуудалд нээлттэй, түүнчлэн парламент дахь олонхи болон цөөнхийг, парламентын гишүүнийг “баглаж, боох”-ын тулд зохиогдоогүй тул ажил хэргээ илүү шулуун, хурдан, шударгаар явуулахын тулд хуралдааны дэгийн зарим заалтыг хэрэглэхгүй байх асуудлыг парламент өөрсдөө шийдэх эрхийн зохицуулалтыг дэгд тусгадаг байна. Жишээ нь, ХБНГУ-ын Бундестагийн хуралдааны дэгийн 126 дугаар зүйлд “Үндсэн хуулийн заалттай харшлахгүй бол зарим онцгой тохиолдолд энэ дэгийг баримтлахгүй байх асуудлыг чуулганы хуралдаанд оролцож буй гишүүдийн 2/3 олонхийн саналаар шийдвэрлэнэ” гэж дэгийг баримтлахгүй байх зохицуулалтыг тусгасан байна. Харин дэгийг түдгэлзүүлэх зохицуулалт Австралийн Төлөөлөгчдийн танхимын хуралдааны дэгийн 47 дугаар зүйлд “1) Урьдчилан мэдэгдсэнээр, эсхүл мэдэгдэлгүйгээр гишүүн нь энэ дэг болон танхимын бусад дэгийг түдгэлзүүлэх санал гаргаж болно; 2) Хэрэв урьдчилан мэдэгдсэнээр түдгэлзүүлэх тухай санал гарсан бол уг саналыг хэлэлцэх асуудлын жагсаалтад оруулж олонхийн саналаар шийдвэрлэнэ; 3) Хэрэв урьдчилан мэдэгдэлгүйгээр түдгэлзүүлэх санал оруулсан бол: а) хэлэлцэж буй асуудалтай холбоотой байх болон тухайн саналыг өөр нэг гишүүн дэмжсэн байх ёстой; б) энэ саналыг зөвхөн үнэмлэхүй олонхийн саналаар шийдвэрлэнэ; в) аливаа дэгийг түдгэлзүүлэх хүрээ нь түдгэлзүүлж байгаа тодорхой зорилгоор хязгаарлагдана.” гэж тус тус заажээ.

- (2) Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 4-т заасан “Улсын Их Хурлын ...үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно.” гэсэн заалт, Улсын Их Хурал хуралдааны дэгээ тогтоолоор бус хуулиар тогтооно гэсэн Үндсэн хуулийн цэцийн 2007 оны 08 дугаар дүгнэлт болон 03 дугаар тогтоол өдгөө үйлчилж байна. Хуралдааны дэгийг баримтлахгүй байх нөхцөлүүдийг сайн жишиг болгож авах боломжгүй боловч тус заалтад парламентын хурлын мөн чанар, амин сүнс оршиж байгааг анхаарч үзэх нь чухал юм.



1.9. Хуралдааны дэгд заагаагүй асуудлыг парламент хэрхэн хэлэлцэх асуудал:

- (1) Хуралдааны дэгд заагаагүй асуудлыг хэлэлцэх журмыг хуралдааны дэгд тодорхой тусгах;
- (2) Хуралдааны дэгийн “энгийн ба хялбар горим”-ыг дэгд тусгах гэсэн зарчмыг хуулийн төсөл боловсруулагчид баримталж ажиллах.

1.10. Хуралдааны дэгийг дагаж мөрдөх:

- (1) Хуралдааны дэгийг дагаж мөрдөх нь гишүүний үүрэг бөгөөд уг үүрэгтэй холбоотой заалтыг УИХ-ын тухай хуулиар бус УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулиар зохицуулах;
- (2) УИХ-ын гишүүн уг үүргийг хэрэгжүүлэхгүй байгаа тохиолдолд сахилгын хариуцлага хүлээлгэх журмыг тогтоож, УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулиар нарийвчлах, тусгай процедур тогтоох.

1.11. Хуралдааны дэгийг сахиулах болон хэрэгжилтэд хяналт тавих:

- (1) УИХ-ын үйл ажиллагааны дэгийн хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэгтэй холбоотой асуудлууд УИХ-ын тухай хуулиар бус УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулиар зохицуулагдана. Цаашид УИХ-ын тухай хууль болон УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн зохицуулах зүйлийн ялгааг эрх зүйн онол, зарчмын хүрээнд тодорхойлж парламентын эрх зүйг хөгжүүлэх шаардлагатай байна.
- (2) Дэгийн хэрэгжилтэд хяналт тавих талаарх ойлголтыг олон улсын жишиг, стандартын дагуу тодорхойлж, оновчтой болгох, илүү нарийвчлах, дэлгэрүүлэх асуудал байгааг анхаарч УИХ-ын чуулганы хуралдааны дэгээр журамлан зохицуулах, уг заалтыг “үр нөлөөтэй” болгох заалтыг хуульд нэмж тусгах.



1.12. Хуралдааны дэг зөрчигчид хүлээлгэх хариуцлага:

- (1) УИХ-ын гишүүн хуралдааны дэгийг дагаж мөрдөхтэй холбоотой үүргийг хариуцлагатай нь уяж, дараах байдлаар УИХ-ын чуулганы хуралдааны дэгд шинээр бүлэглэн зохицуулах:
 - o УИХ-ын үйл ажиллагаанд оролцох гишүүний үүрэг ба үүсэх хариуцлага;
 - o Нэгдсэн болон Байнгын хорооны хуралдааны бүхий л үе шатанд дэгийг баримтлах үүрэг ба үүсэх хариуцлага;
 - o УИХ болон танхимд, бусдад хүндэтгэлтэй хандах ба үүсэх хариуцлага.
- (2) Хариуцлагын үр нөлөөтэй олон төрлийг хуульчлах.
- (3) Нэгдсэн болон байнгын хорооны хуралдаан даргалагч УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 101 дугаар зүйлд заасан хариуцлагыг УИХ-ын гишүүнд хүлээлгэх зайлшгүй шаардлагатай үндэслэлүүд бүрэн хуульчлагдаагүй байх тул хариуцлага хүлээлгэх процессын журмыг нэг бүрчлэн хуульчлах. Хариуцлага ногдуулсан гишүүн уг хариуцлагыг хүлээн зөвшөөрөхгүй тохиолдолд уг маргааныг хэрхэн яаж шийдвэрлэх, нөгөө талаас дэгийн тухай хуулийн дагуу үг хэлэх эрхээ хасуулсан болон хуралдаанд суух эрхээ 3 цагаар хасуулсан гишүүн өөрийгөө өмгөөлөх, шийдвэрийг эсэргүүцэх эрхээр хангагдах (Герман, Франц, Солонгос улсын дэгд ийм заалт байгаа), улмаар хариуцлага хүлээлгэсэн шийдвэр хууль ёсны гэж хүлээн зөвшөөрөгдөх нөхцөл зэргийг шинээр зохицуулах.
- (4) Манай хуулийн хэм хэмжээ гол төлөв хэн, юу хийх эрх, үүрэгтэйг заадгийг бид мэднэ. Энэ бол манай улсын хууль тогтоох ажиллагаан дахь дутагдлын нэг. Жишээ нь, УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10¹.1-д "хуралдаан даргалагч хуралдааны дэг зөрчигдвөл "таслан зогсооно", 10.1.1-д "Гишүүн хуралдааны дэг зөрчсөн бол хуралдаан даргалагч... хариуцлага хүлээлгэнэ", УИХ-ын тухай хуулийн 12.4-т "УИХ-ын дэд дарга нь УИХ-ын үйл ажиллагааны дэгийн хэрэгжилтэд



хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлнэ.” гээд тунхаглачихсан. Энэхүү тунхаг заалтууд нь хуульд ингэж бичигдснээрээ шууд хэрэгжихгүй. Харин түүнийг хэзээ, хаана, яаж (ямар арга хэлбэрээр) хэрэгжүүлэхийг тэр бүр заадаггүй. Эдгээрийг гагцхүү процессын хэм хэмжээгээр л журамлаж, тохируулах боломжтой. Гэтэл УИХ-ын тухай болон УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн заалтууд, түүнийг хэрэглэх процедур байхгүй учир хоосон тунхаг болсоор ирснийг нуух шаардлагагүй. Хууль тогтоогчид энэ бодит байдлыг хүлээн зөвшөөрч, хуралдааны дэгд хэн (УИХ-ын дарга, дэд дарга, хуралдаан даргалагч, гишүүн) ямар эрх, үүрэгтэй вэ гэж давхар, давхар хуулбарлан заахгүйгээр “юуг хэзээ, хаана, яаж хийх вэ?” гэдэг арга ажиллагааны амин чухал ач холбогдолтой асуудлыг журамлан хуралдааны дэгээ шинэтгэх зайлшгүй шаардлага байгааг зөвлөж байна.

1.13. Хуралдааны дэг зөрчсөнд тооцож ногдуулсан шийтгэлийг эсэргүүцэх:

- (1) УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10¹ дугаар зүйлд заасан хуралдааны дэг зөрчигчид сануулах арга хэмжээ авах, асуулт асуух, үг хэлэх эрхийг хасах, хуралдаанд оролцох эрхийг 3 цагаар хасах, үг хэлэх хугацааг шууд дуусгавар болгох зэрэг хариуцлагыг хүлээлгэх бол тухайн гишүүнд өөрийгөө өмгөөлөх, гомдол гаргах эрхийг нээж өгөх. Учир нь хуулийн ямар нэг процедургүйгээр хүний эрхийг хөндөж хязгаарлах боломжгүй. Энэ баталгаа УИХ-ын гишүүнд ч гэсэн үйлчлэх тул ХБНГУ, Франц, Солонгос улсын парламентад хэрэглэгдэж байгаа зохицуулалтыг судалж, авч хэрэгжүүлэх.

1.14. Хуралдааны дэг ноцтой зөрчигдвөл парламент түр завсарлах:

- (1) УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10.1.2-т заасан дэгийг сахиулахтай холбоотой хуралдаан даргалагчид хүлээлгэсэн үүргийг үр дүнтэй хэрэгжүүлэх механизмыг



журамлан тогтоох. Хуралдаан даргалагчийн хуралдаан удирдан явуулах, дэг сахиулах, дэг зөрчигдвөл авах арга хэмжээг дэгийн тухай хуульд нарийвчлан тогтоож өгөх нь тухайн парламентын нэр хүнд, үр нөлөөтэй байдлыг нэмэгдүүлэхэд ач холбогдолтой юм. Зарим улсын парламентын хуралдаан даргалагч дэг зөрчигдвөл хуралдааныг түр завсарлуулах тухайгаа мэдэгдэх, эсхүл танхимыг орхин гарах үед хэлэлцүүлэг шууд зогсож завсарладаг байна.

Хоёр. Анхдугаар чуулган буюу Улсын Их Хурал өөрийгөө зохион байгуулах хуралдааныг хуралдуулах журам

- (1) УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 11.1.1-д “Ерөнхийлөгч чуулганы хуралдааныг даргалж”, 11.2-т “Шинээр сонгогдсон Улсын Их Хурлын гишүүдийн тангараг өргөх ёслол үйлдэж дуустал Ерөнхийлөгч ...чуулганы хуралдааныг зохион байгуулж даргална.” гэж хуульчилсан нь парламентат ёсны зарчмаас гажсан буюу “парламентын өөрийгөө зохион байгуулж хуралдаанаа явуулах” зарчимтай нийцэхгүй байгааг анхаарч бусад орны дэгд зааснаар тус хуралдааныг УИХ-д хамгийн олон удаа сонгогдсон, эсхүл насаар хамгийн ахмад гишүүн (*ХБНГУ, ОХУ-ын парламент*) даргалж хуралдуулдаг туршлагыг авч хэрэгжүүлэх;
- (2) УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд Анхдугаар чуулган, түүнийг товлон зарлахтай холбоотой заалт байхгүй байгаа бөгөөд уг асуудлыг УИХ-ын тухай хуулийн 14 дүгээр зүйлээр зохицуулсан байна. Анхдугаар чуулгантай холбоотой асуудлыг материаллаг хэм хэмжээнээс бүрдсэн УИХ-ын тухай хуулиар бус процессын хэм хэмжээнээс бүрдсэн үйл ажиллагааны журмыг зохицуулсан хуралдааны дэгээр бүхэлд нь зохицуулах нь зүйтэй;
- (3) УИХ-ын чуулганы хуралдааныг анхдугаар, ээлжит, ээлжит бус, онцгой чуулган гэж дөрөв ангилж хуульчилдаг. Ингэж ялгаа заагтай болгосон нь хууль зүйн ихээхэн үр дагавартай. Анхдугаар чуулган нь улс орны дээд удирдлагыг зохион байгуулдаг өндөр хариуцлагатай чуулган. Түүнийг сонгууль



болсон өдрөөс хойш нэг сарын дотор зарлан явуулах Үндсэн хуультай. Хэрэв анхдугаар чуулган асуудлаа шийдэхгүй бол төрийн хууль тогтоох, гүйцэтгэх бүх ажил зогсож улс орон удирдлагагүй болно гэсэн үг.² Иймд парламентат ёс хөгжсөн улс оронд Ерөнхийлөгч нь парламентын анхдугаар хуралдааныг даргалж зохион байгуулдаг жишиг байхгүй байгаа болон Монгол Улсын Их Хурлын 5 дахь удаагийн сонгуулиар байгуулагдсан парламент (2008-2012)-ын анхдугаар чуулган дээр үүссэн кейс (*Ерөнхийлөгч-хуралдаан даргалагч, тангараг өргөх, гишүүний бүрэн эрх, бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх, хуралдааны ирц гэх мэт*)-ийг бүхэлд нь нарийвчлан судалж, холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах.

- (4) Харьцуулсан судалгаагаар парламентын гишүүн тангараг өргөхгүй тохиолдолд мандатаасаа татгалзсан гэж үздэг хууль зүйн үр дагаврыг ихэнх улсын парламент хуульчилсан байна. Үндсэн хуулийн эхийг баригч, гавьяат хуульч Б.Чимид Монгол Улсын Их Хурлын 5 дахь удаагийн сонгуулиар байгуулагдсан парламент (2008-2012)-ын анхдугаар чуулган дээр үүссэн тангараг өргөхтэй холбоотой асуудлыг тухайн үед *"...Тангараг өргөхтэй холбогдсон энэ гаж үзэгдэл зөвхөн Монголд л байдаг байх. Болзол тавьдаг, тэгвэл өргөнө, ингэвэл өргөхгүй гэж, ...Тангараг өргөхөд ямар ч болзол тавих ёсгүй."*³ гэж дүгнэжээ. Тэгэхлээр тангараг өргөнө, өргөхгүй гэдэг бол гишүүний хувьд сайн дурын асуудал биш. УИХ-ын гишүүнээр сонгогдсон хүний заавал биелүүлэх үүрэг бөгөөд тангараг өргөхийн гол учир ард түмнээс сонгогдсон элчийн хувьд түр үнэмлэхээ авсан этгээд хууль тогтоогчийн хувиар хууль батлах, тогтоох эрхээ олж авахтай холбоотой аж. Гэтэл одоо үйлчилж байгаа УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 11.1.3-т *"...насаар хамгийн ахмад гишүүн гишүүний тангараг уншиж бусад гишүүд нь давтан хэлж тангараг өргөх, насаар хамгийн ахмад гишүүн гишүүний тангараг унших боломжгүй бол насаар ахмад дараагийн гишүүн гишүүний тангаргийг уншиж бусад гишүүд нь давтан хэлж тангараг өргөх"* гэсэн ганц

2 Б.Чимид. *Төр, нам, эрх зүйн шинэтгэлийн эгзэгтэй асуудал. Нэгдүгээр дэвтэр. УБ., 2008. 231 дэх тал.*

3 *Мөн тэнд 236 дахь тал.*



“материаллаг” заалт л байна. Иймд 2008 онд УИХ-ын зарим гишүүд болзол тавьж тангараг өргөх, өргөхгүй асуудалтай холбоотой үүссэн асуудлаас хойш 10 жил өнгөрч байхад гишүүн тангараг өргөхгүй тохиолдолд үүсэх хууль зүйн үр дагавартай холбоотой заалтыг одоо болтол хуульчлаагүй байгааг анхаарч, холбогдох хуульд нэмэлт оруулах.

Гурав. Хуулийн төсөл хэлэлцэх журамтай холбоотой зөвлөмж

- (1) УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд хууль, УИХ-ын бусад шийдвэрийн төслийг хэлэлцэхдээ хэдэн үе шаттай хэлэлцэх болон өргөн мэдүүлснээс хойш хэд хоногийн дотор хэлэлцэх эсэх, анхны хэлэлцүүлэг, эцсийн хэлэлцүүлгийг хийх хугацааг тодорхой хуульчлах;
- (2) Харьцуулсан судалгаагаар ОХУ-ын Төрийн Думаас бусад улс орны парламентууд хууль санаачлагчаас өргөн мэдүүлсэн хуулийн төслийг шууд нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж, дараа нь аль Байнгын хороонд хуваарилах асуудлыг хамтын зарчмаар шийдвэрлэдэг механизмтай байна. Өөрөөр хэлбэл, хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Байнгын хороо (10-19 гишүүнтэй) бус УИХ-ын нэгдсэн хуралдаан (76 гишүүн)-аар эхэлж хэлэлцдэг жишиг. Хууль санаачлагчаас өргөн барьсан хуулийн төслийг аль Байнгын хороонд хуваарилах асуудлыг УИХ-ын дарга бус УИХ-ын нийт гишүүн хуралдаанаараа шийдвэрлэнэ. Иймд манай улсын парламентад 26 жил үйлчилсэн хуулийн төсөл хэлэлцдэг журмыг бүхэлд нь өөрчилж, төслийг эхлээд нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж, дараа нь Байнгын хороонд хуваарилдаг бусад орны “сайн” туршлагыг нэвтрүүлж, УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд холбогдох нэмэлт, өөрчлөлт оруулах.



Дөрөв. Хуралдаан даргалагчийн эрх зүйн байдал болон хуралдаан даргалах дэгтэй холбоотой зөвлөмж

- (1) Парламентын дарга буюу хуралдаан даргалагч нь улс төрийн нам, эвслээс нэр дэвшигдэн сонгогддог боловч аль нэг нам, олонхийн улс төрийн эрх ашгийг илэрхийлэн хамгаалагч биш, харин парламент дахь улс төрийн намуудын үзэл бодлын зөвшилцлийн зуучлагч, зохицуулагч байх ёстой гэсэн хандлага өдгөө ажиглагдаж байна. Үүний үр дүнд Спикер нь харьяалсан улс төрийн намын үйл ажиллагаанаасаа бүрэн татгалздаг (*манайхаас бусад оронд*) жишиг тогтжээ. Нөгөө талаас, спикерт нэр дэвшүүлэх давуу эрхийг парламентад олонхийн суудал авсан нам эдэлж, парламентын даргад өөрсдийн хүнийг дэвшүүлэх ёстой боловч гишүүдийн олонхийн санал авч чадаагүй бол спикер заавал хамгийн хүчтэй фракцаас нэр дэвшиж сонгогдох албагүй байна. Учир нь спикер бол Ерөнхий сайд биш, аль нэг намын эрх ашгийг хамгаалагч биш. Хэрэг дээрээ спикер тодруулсан нам нэг суудлаа алддаг гэж үздэг байна. Иймд УИХ-ын даргын албан тушаалыг парламентын ёс зүй, парламент дахь улс төрийн соёлыг агуулан илэрхийлэгч байх ёстой гэсэн хандлагын үүднээс уг албан тушаалыг намын гишүүнчлэлээс түдгэлздэг албан тушаалд тооцох өөрчлөлтийг УИХ-ын болон дэгийн тухай хуульд хуульчлах;
- (2) УИХ-ын даргын албан тушаал нь одоо үйлчилж байгаа хууль тогтоомжоор улс төрийн намын гишүүнчлэлээс түдгэлздэггүй албан тушаал тул УИХ-ын дарга нь хуралдаан даргалагчийн хувьд хэлэлцүүлэгт оролцож үг хэлэхдээ суудлаа орхих, мөн санал хураалтад оролцохгүй байх зэрэг парламентад ёс өндөр хөгжсөн улс орны “сайн” жишгийг судалж, нэвтрүүлэх, холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах;

Тав. Цөөнхийн эрх ба хуралдааны дэгтэй холбоотой зөвлөмж

- (1) Парламент ил тод байх ёстой. Аливаа асуудлыг “нуудаг” биш, “нээдэг” байх ёстой. Учир нь парламент бол ард түмний



төлөөллийн танхим. Ард түмэн, Засгийн газар хоёрын хооронд Улсын Их Хурал гүүр болох учиртай. Гэвч Улсын Их Хурал нь гүүр биш “хөшиг” болоод хувирсан байна. Иймд энэ байдлыг засах, тодруулбал Улсын Их Хурал чиг үүргээ сайн хэрэгжүүлэхийн тулд парламентын хяналт, хариуцлагын тогтолцоог сайжруулах нь зүйтэй.

Парламентын хяналт гэдэг бол цөөнхид буюу сөрөг хүчинд байх ёстой. Манай парламентад Улсын Их Хурал дахь олонхи, цөөнхийн тухай л ярьдаг болохоос сөрөг хүчин, эрх баригчийн тухай ярьдаггүй. Иймд Улсын Их Хурлын тухай болон чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд цөөнхийн эрхтэй холбоотой заалт болон сөрөг хүчнээс олонхид тавих хяналтын талаар огт хуульчлаагүй байгааг анхаарах.

- (2) Парламентыг амьд байлгадаг организм нь олонхи, цөөнх юм. Гэтэл манай парламент яагаад сөрөг хүчингүй “болчихсон”-ыг судалж, цаашид анхаарах ёстой.

Парламентын хамгийн том чиг үүрэг бол “сөрөг хүчин”-ээ амьд байлгах явдал. Цөөнх байнга олонхийн алдааг олж харахыг хүснэ. Ингэснээр парламентын хяналт үр ашигтай болно. Парламентын хяналтыг сайжруулж, хяналтыг олонхи биш, цөөнх хэрэгжүүлэх механизмыг сайжруулах нь чухал. Иймд цөөнхийн эрх болон цөөнх, сөрөг хүчнээс тавих хяналтыг олон улсын жишиг, зарчмын хүрээнд тодорхойлж, УИХ-ын чуулганы хуралдааны дэгээр журамлан зохицуулах шаардлага байгааг зөвлөж байна.

Зургаа. Монгол Улсын Их Хурлын тухай хууль болон Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн заалт хоорондын давхцал болон хийдэл, хуулийн системчлэлийн үүднээс хэрхэн шийдвэрлэх талаархи зөвлөмж

- (1) УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль болон УИХ-ын тухай хуулиудыг бүхэлд нь харьцуулан хянан үзэж, хуулийн заалтуудын давхцлыг “цэвэрлэх”, “балансжуулах” үндсэн дээр



дэгийн тухай хуулийн зохицуулах чадварыг нэмэгдүүлэх;

- (2) Үндсэн хууль болон УИХ-ын тухай хуулиудыг хуулж, дэг болгосон байдалтай байх бөгөөд УИХ-ын тухай болон УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн заалтын агуулгын болон хэлбэрийн давхцал их байна. Тухайлбал, УИХ-ын тухай хуулийн **26.5, 26.7, 22.4, 29, 13.6, 11.13, 11.6, 7.1.2, 29.9** гэсэн заалтууд нь УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн **13.1, 13.2, 15.1, 5, 6, 7, 8, 9, 4.1, 4.5, 8.1.3, 16.1.1** гэсэн заалтуудтай агуулгын болон хууль зүйн техник бичилтийн хувьд давхцалтай байгааг анхаарч холбогдох хуулиудад өөрчлөлт оруулах. Энэ нь олон хүчин зүйлээс шалтгаалж байгаа боловч гол үндэслэл бол хуулийн төсөл боловсруулах ажиллагаа сул байгаатай холбоотой гэж үзэж байна.
- (3) Эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулбал зохих харилцааны зарчмын гол гол асуудлыг нь олж харах. УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль бол “үйл явцын” буюу “процессийн журам”-аас бүрдэх учиртай гэдэг”-ийг хууль санаачлагч болон хуулийн төсөл боловсруулагч ямагт анхаарах. Энэ бол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийг боловсруулахад болон түүнд нэмэлт, өөрчлөлт оруулахад баримтлах “алтан дүрэм” гэж хэлж болно. Иймд Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулиар зохицуулагдах “ёстой” процессийн журмыг агуулсан заалтууд байгаа боловч өдгөө Улсын Их Хурлын тухай хуулиар зохицуулагдаж байгаа дараах заалтуудыг хүчингүй болгож, дэгийн тухай хуульд нэмж хуульчлах. Үүнд:
- **&14.5.** (УИХ-ын чуулганы хуралдааны дэгийг шинэчлэн батлах журам);
 - **&6.8, 6.13, 6.15, 6.16.** (Улсын Их Хурлын гишүүнийг чөлөөлөх, эгүүлэн татах, бүрэн эрхийг түдгэлзүүлэхтэй холбоотой журам);
 - **&9.** (Улсын Их Хурлын даргыг сонгох журам);
 - **&10.** (Улсын Их Хурлын даргын бүрэн эрхийн хугацаа, түүнийг хугацаанаас нь өмнө чөлөөлөх, огцруулах);
 - **&12.1-12.3.** (Улсын Их Хурлын дэд даргыг сонгох, чөлөөлөх, огцруулах журам);
 - **&24.9, 24.10.** (Дэд хорооны даргыг сонгох журам);



- **&31.2, 31.3, 31.5-31.11.** (УИХ-ын бүрэн эрх хугацаанаас өмнө дуусгавар болох журам)
- (4) УИХ-ын олон талт үйл ажиллагааны ангиллыг зөв хийж, эзэн, цаг хугацаа, хэмжээ зэргийг тод тогтоосон процессийн заалтуудаас бүрдсэн УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийг дахин боловсруулах. Үүний тул өөрийн хийгээд дэлхийн улсуудын хүлээн зөвшөөрөгдсөн арга туршлагыг судалж, орчин үеийн эрх зүйн шинжлэх ухааны онолын түвшинд хүртэл боловсруулах шаардлагатай гэж үзэж байна. Иймд:
- Парламентын сонгуулийн;
 - УИХ-ын үүсгэн байгуулах үйл явцын (Засгийн газрыг болон бусад байгууллагыг байгуулах, зөвшилцөх, хариуцан тайлагнах зэрэг);
 - Өөрийн зохион байгуулалтын (бүтцийг тогтоох, хороодыг байгуулах, өөрчлөх, гишүүдийн бүрэн эрх, халдашгүй байдал, сахилга хариуцлагын зэрэг асуудлыг шийдвэрлэх);
 - Хууль гаргах (санаачлах, хэлэлцэх, батлах, нийтлэх);
 - гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага, нам, иргэний нийгмийн бусад байгууллагатай харилцан ажиллах;
 - Хяналт шалгалт, мэдээллийн;
 - Маргаантай асуудал, саналын зөрөөг хянан шийдвэрлэх ажиллагааны;
 - Санхүүгийн үйл ажиллагаа, төсвийн үйл явцын;
 - Гадаад харилцааны болон олон улсын үйл ажиллагаа, гэрээний;
 - УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд болон Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журам зэрэг бүлэг, дэд чиг үүрэг, тэдгээрийг хэрэгжүүлэх олон зүйл тодорхой ажилбарыг **хэн, хэзээ, хэрхэн, яаж үүсгэх, хэлэлцэх, шийдвэрлэх**, түүнээ хэрэгжүүлэх дүгнэх арга хэлбэр, хугацаа, журам үүрэг, үр дагавар зэргийг хамруулсан процессийн заалтуудаас бүрдүүлж системчлэх.



Долоо. Үндсэн хуулийн цэцээс Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн холбогдох зүйл, заалт Үндсэн хууль зөрчсөн гэж гаргасан дүгнэлт, тогтоолыг судалсан шинжилгээтэй холбоотой зөвлөмж

- (1) Үндсэн хууль ёсны болон аюулгүй байдлын онолоор хууль тогтоогчид Үндсэн хууль, түүний үзэл баримтлалыг, мөн Үндсэн хууль болон үндсэн хуульчилсан органик хуулийн уялдаа холбоог онолын үүднээс зөв ойлгох, хэрэглэх хэрэгтэй байна. Энэ бол хууль тогтоох үйл ажиллагааны амин сүнс мөн.
- (2) Улсын Их Хурлын хууль тогтоох үйл ажиллагаа мэргэшээгүй. Улсын Их Хурлын тухай, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулиуд нь Үндсэн хууль, түүний ерөнхий үзэл санаа, зарчмыг материаллаг болон процессийн хэм хэмжээгээр, утга агуулгаар задлан тайлбарласан хэм хэмжээнээс бүрдэх нь байтугай хууль тогтоогчдын, улс төрийн намын явцуу ашиг сонирхол, санаатай болон болгоомжгүй алдсан “алдаа”-наас бүрдсэн олон зүйл хэм хэмжээгээр ил тод харагдаж байна.

Эрх зүйн онолоор бол хуулийг хэмжээ, зэрэг, учир холбогдлоор нь Үндсэн хууль, Үндсэн хуульчилсан хууль, ердийн хууль гэж, нийгмийн харилцаанд нөлөөлөх байдлаар нь материаллаг хууль, процессын хууль гэхчлэн ангилдаг. Гэтэл Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн хэм хэмжээ процессын хэм хэмжээнээс бүрдэхгүй байгааг анхаарах хэрэгтэй. Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль нь Үндсэн хуулийн цэцээс Үндсэн хууль зөрчсөн гэсэн дүгнэлт, тогтоол олон гаргасан хууль болох нь судалгаагаар харагдаж байна. Энэ хариуцлагагүй байдлыг хууль тогтоогчид Үндсэн хуулиа дээдлэснээр засаж болно. Ингэхийн тулд Улсын Их хурал **“Үндсэн хуулийн болон парламентын дэгийн хороо”**-г байгуулах ёстой. Мөн **“Үндсэн хуульчилсан шинэтгэл”**-ийг хийх хэрэгтэй байна. Учир нь Үндсэн хуульчилсан хуулиудыг Үндсэн хуульд нийцүүлэх “гүн боловсруулалт”⁴ тулгамдсан асуудал болж байна.

4 Б.Чимид. Монгол Улсын Үндсэн хуулийн эрх зүйн хөгжлийн нэн тулгамдсан асуудлууд. “Монгол Улсын эрх зүйн хөгжлийн асуудлууд” эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлийн эмхтгэл. УБ., 2011. 103 дахь тал.



- (3) Хууль бүтээхийн хариуцлагыг монголд ухаарах цаг болсон. Хууль тогтоох ажиллагаа мэргэшээгүй, мөн өмнөх муу уламжлалд тулгуурлан хэрэгжүүлэх арга ажиллагааг нарийн хуульчлаагүй, ерөнхий, дур зоргын захиргаадлын, тунхагийн шинжтэй хуулиудыг голчлон батлан гаргасаар ирсэн нь хууль биелүүлэх, хэрэгжүүлэх ажиллагаанд томоохон доголдол гарч, хуульчид болон **эрх зүйн боловсрол**, сургалтын өмнө ноцтой бэрхшээл үүсгэж байна. Хэрэгжүүлэх механизмгүй зөрчилдсөн тунхагийн шинжтэй хуулиуд дээр тулгуурласан сургалт нь хууль дээдлэх итгэл үнэмшилтэй эрх зүйчдийг бэлтгэх бололцоог алдагдуулж байна. Энэ хариуцлагыг Улсын Их Хурал, түүний удирдлага, ажлын алба, хуульчид, зөвлөхүүд ч гэсэн хүлээх хэрэгтэй. Иймд **Үндсэн хуулийн боловсрол, Үндсэн хуулийн эрх зүйн хариуцлагыг** хууль тогтоох үйл ажиллагааны хүрээнд бий болгох, **түүнчлэн парламентын хуралдааны дэгд агуулагдах онол, зарчим, хууль зүйн техникийг мэдэх, судлах** зайлшгүй шаардлага байна. Энэ ажлыг алгасвал Үндсэн хууль тогтворгүй болж түүний дархлаа, хамгаалалт алдагдах болно.

Найм. УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулиар зайлшгүй зохицуулах зүйлтэй холбоотой зөвлөмж

- (1) Монгол Улсын Үндсэн хуулийн зарим заалтуудтай холбоотойгоор үүссэн асуудлыг Улсын Их Хурал нэгдсэн болон Байнгын хорооны хуралдаанаараа авч хэлэлцэх дэгийг одоо хүртэл боловсруулаагүй байгааг анхаарч УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулиар зохицуулах. Үүнд, Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин наймдугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан “Байнгын хорооны бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг **Улсын Их Хурал** тогтооно.”, Гучин хоёрдугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан “Ерөнхийлөгч сонгогдсоноосоо хойш 30 хоногийн дотор **...Улсын Их Хуралд** тангараг өргөнө.”, Гучин дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан “Ерөнхийлөгчийн зарлиг хуульд нийцээгүй бол **...Улсын Их Хурал** хүчингүй болгоно.”, Гучин долдугаар



зүйлийн 1 дэх хэсэгт заасан “Ерөнхийлөгчийг түр эзгүйд бүрэн эрхийг нь **Улсын Их Хурлын дарга** хэрэгжүүлнэ.”, мөн зүйлийн 2 дахь хэсгийн “...Энэ тохиолдолд **Улсын Их Хурал** Ерөнхийлөгчийн сонгуулийг дөрвөн сарын дотор зарлан явуулна.”, мөн зүйлийн 3 дахь хэсэгт заасан “**Улсын Их Хурлын дарга** Ерөнхийлөгчийн үүрэг гүйцэтгэх журмыг хуулиар тогтооно.”, Дөчин тавдугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан “Засгийн газрын тогтоол, захирамж нь хууль тогтоомжид нийцээгүй бол **...Улсын Их Хурал** хүчингүй болгоно.”, Жаран наймдугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан “Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах санаачилгыг хууль санаачлах эрх бүхий байгууллага, албан тушаалтан гаргах бөгөөд саналыг Үндсэн хуулийн цэц **Улсын Их Хуралд** өргөн мэдүүлж болно.”, Жаран есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан “Үндсэн хууль, түүнд оруулах нэмэлт, өөрчлөлтийг **Улсын Их Хурлын** нийт гишүүний дөрөвний гурваас доошгүйн саналаар **батална.**”, мөн зүйлийн 2 дахь хэсгийн “Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийг **Улсын Их Хуралд хоёр удаа авч хэлэлцэхэд** ийнхүү нийт гишүүний дөрөвний гурваас доошгүйн санал авч эс чадвал уул төслийг ээлжит сонгуулиар сонгогдсон **Улсын Их Хурлын шинэ бүрэлдэхүүн** ажлаа эхэлтэл дахин авч хэлэлцэхгүй.” гэсэн заалтууд болно;

- (2) Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг УИХ-д хууль санаачлагчаас өргөн барих тохиолдолд нэгдсэн хуралдаан болон Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх дэг УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулиар зохицуулагдаагүй байгааг анхаарч нэн даруй дэгийн хуульд нэмэлтээр оруулах шаардлага үүсэж байна. Хэдийгээр Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулиар зохицуулж байгаа боловч УИХ-ын тухай хуулийн 32.1-д “...хуралдаанаар хууль, УИХ-ын бусад шийдвэрийн төсөл, тодорхой бусад асуудал хэлэлцэх, санал хураах, батлах, шийдвэр гаргахдаа УИХ-ын чуулганы хуралдааны дэгийг баримтална.” гэж хуульчилсан байгааг анхаарах. Харьцуулсан судалгаагаар нийт 43 орны парламентын хуралдааны дэгд Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг хэлэлцэх журмыг тусгасан байна;



- (3) Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийг батлах, түүнд оруулах нэмэлт, өөрчлөлтийн журмыг УИХ-аар хэлэлцэхтэй холбоотой заалтыг шинээр хуульчлах. Ерөнхийлөгч, Засгийн газар бус зөвхөн Улсын Их Хурлын гишүүд өөрсдийн үйл ажиллагааныхаа хуралдааны дэгд нэмэлт, өөрчлөлт оруулах эрхтэй болохыг Улсын Их Хурлын болон холбогдох хууль тогтоомжуудаар журамлан зохицуулах. Түүнчлэн Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд дэгийн асуудлаар санаачилсан төслийг хэлэлцэх асуудлын дараалал баримтлахгүй хэлэлцүүлэгт шууд оруулах тухай заалтыг тусгайлан хуульчлах.
- (4) УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн зарим зүйл, заалтыг зөв хэрэглэх талаар нэгдсэн болон Байнгын хорооны хуралдаан дээр маргаан гарсан тохиолдолд дэгийн хуулийн заалттай холбоотой тайлбарыг хуралдаан даргалагч хийх, түүний хэлсэн тайлбартай холбоотой маргаан гарсан тохиолдлыг хэрхэн шийдвэрлэх журмыг шинээр хуульчлах.
- (5) Хуралдааны дэгд заагаагүй асуудлыг хэрхэн хэлэлцэх журмыг хуралдааны дэгийн тухай хуульд шинээр хуульчлах.

